

Sight For-н

Хүүхэд хамгааллын хөтөлбөр



Хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгөөс ангид байж, аюулгүй байх эрхтэй. Хүүхдийг хамгаалах хэрэгцээ бүх нийгэмд чухал юм. Дэлхий даяар хүүхдүүд хүчирхийлэл, мөлжлөгт өртөж, бэлгийн, бие махбодын болон сэтгэл зүйн дарамттай тулгарч байна. Тэдний ихэнх нь аливаа мөлжлөгийн үйлдэлд тухайлбал ашгийн төлөөх бэлгийн мөлжлөгт өртөж байна.

Sight For All нь хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөгийг ямар ч тохиолдолд хүлээн зөвшөөрөх ёсгүй гэж үздэг. Хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалагдаж, аюулгүй байх эрхтэй бөгөөд Sight For All хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөгийг үл тэвчих хандлагыг баримталдаг.

Sight For All-н Хүүхэд хамгааллын бодлого нь хамтран ажилладаг хүмүүсийнхээ тэр дундаа хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах зорилготой.

Энэхүү хуудас нь Sight For All-н хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хуурангуй бөгөөд хөтөлбөрийн бүх мэдээлэл ороогүй гэдгийг анхаарна уу.

Sight For All-н хүүхэд хамгааллын бодлого нь Sight For All-н бүх ажилтанд хамаарах ба үүнд: Удирдах зөвлөлийн гишүүд, ажилтнууд, эрүүл мэндийн сайн дурын ажилтнууд (зохицуулагчид), эмнэлгийн бус сайн дурын ажилтнууд, нүдний эмч нар, хамтран ажиллагсад, төслийн оролцогчид, нүдний тасгийн эрхлэгч, гэрээт ажилтан, Sight For All төсөлд хамрагдсан орон нутгийн төлөөлөгчид болон Sight For All-тай албан ёсны гэрээтэй хамтран ажиллагч байгууллагууд орно.

Уг бодлого нь таван зарчимд тулгуурладаг:

Зарчим 1: Хүүхдийн мөлжлөг, хүчирхийллийг үл тэвчих

Зарчим 2: Хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх

Зарчим 3: Эрсдэлийн талаарх мэдлэг, менежмент

Зарчим 4: Хүүхдийн аюулгүй байдлын талаарх үүрэг хариуцлага

Зарчим 5: Мэдээлэл болон хэрэг шийдвэрлэх үйл явцын шударга байдал

Үндсэн Тодорхойлолтууд

ХҮҮХЭД:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцод заасны дагуу "хүүхэд" гэж хүүхдэд хамаарах хуулийн дагуу насанд хүрээгүй 18-аас доош насны хүн бүрийг хэлнэ.

ХҮЧИРХИЙЛЭЛ:

Биеийн махбодын хүчирхийлэл—хүүхдийн эсрэг бие махбодын хүч хэрэглэх, улмаар хүүхдэд хор хөнөөл учруулах. Биеийн махбодын хүчирхийлэлд түлхэх, цохих, алгадах, сэгсрэх, шийдэх, цохих, өшиглөх, хазах, шатаах, боомилох, хор учруулах зэрэг орно.

Үл тоомсорлох—эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэдээ тэдний бие махбод, сэтгэл санааны хөгжил, сайн сайхан байдалд зайлшгүй шаардлагатай хэмээн тухайн нийгэмд хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр хангахгүй байх (хангах боломжтой нөхцөл байдалд).

Сэтгэл зүйн хүчирхийлэл—эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэд зохисгүй үг хэллэг эсвэл үйлдлээр хандах эсвэл хүүхдэд сэтгэлзүйн хүмүүжил болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадварыг хангалттай суулгаж чадалгүй урт хугацаанд үргэлжилсэн хэв маягийг хэлнэ. Иймэрхүү үйлдлүүд хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмж, нийгмийн харилцах чадварт сөргөөр нөлөөлөх өндөр магадлалтай.

Бэлгийн хүчирхийлэл—насанд хүрсэн хүн эсвэл ах эсвэл эгч мөн өсвөр насныхан тухайн хүүхдийг бэлгийн таашаал авах зорилгоор ашиглах. Бэлгийн хүчирхийлэлд бэлгийн эрхтэнд хүрэх, гар хангалга хийх, аман секс хийх, шодоо, хуруу болон бусад зүйлийг үтрээ болон шулуун гэдэсрүү оруулах, хөхийг илэх, гаж донтой зүйл хийх, хүүхдэд порнограф үзүүлэх, татан оролцуулах зэрэг багтана.

ХҮҮХДИЙН МӨЛЖЛӨГ БА ХҮЧИРХИЙЛЭЛ: нэг болон түүнээс олон сонголттой:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх эсвэл хүчирхийлэл үйлдүүлэхээр өөр хүнийг ятгах, албадах.

- Хүүхдийн мөлжлөгтэй холбоотой материалыг эзэмших, хянах, боловсруулах, түгээх, олж авах эсвэл дамжуулах.

- Биеэр эсвэл цахим орчинд хүүхдийг хүчирхийлэх зорилгоор хуурамч итгэлцэл үүсгэн, дотносох эсвэл өөр хүнээр хуурамч итгэлцэл үүсгэж, дотносох үйлдлийг албадан хийлгүүлэх.

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ:

Хүүхдийг хор хөнөөлийн аль ч хэлбэрээс, ялангуяа хүүхдийн мөлжлөг, хүчирхийллээс үүдсэн хор хөнөөлөөс хамгаалах зорилготой үйл ажиллагаа эсвэл санаа санаачлага.

Хөтөлбөрийн хэрэгжилт

Sight For All-н хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн шаардлагууд тавигдана. Sight For All нь доор дурдсан арга замуудаар хүүхдийн аюулгүй байдлыг хангахыг эрмэлздэг.

Ажилтан шалгаруулж авахад тавигдах шаардлага

Sight For All байгууллага нь ажилтан сонгон шалгаруулахдаа тухайн ажил албанд тохирох чадамж бүхий хүмүүсийг шалгаруулж авах бөгөөд хүүхэд залууст эрсдэл бүхий хүмүүсийг шууд болон шууд бусаар үйл ажиллагаанд оролцуулахгүйг эрмэлзэнэ.

Сургалт

Sight For All-н бүх удирдах зөвлөлийн захирлууд, ажилтнууд, зохицуулагчид, сайн дурын ажилтнууд, нүдний эмч нар, хамтран ажиллагсад, төслийн оролцогчид, төслийн хамтрагчид, зөвлөхүүд болон гэрээт гүйцэтгэгчид нь нэг хуулбарыг хүлээн авч хүүхэд хамгааллын бодлого болон эмзэг бүлгийн иргэдтэй харилцах ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурсан байна. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой сайн туршилга бүрийг хөгжүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулна.

Хамтын ажиллагаа

Sight For All -ийн хамтрагч төрийн бус байгууллагууд хүүхэд хамгааллын стандартыг баримтлан ажиллана.

Sight For All нь Засгийн газар болон хамтран ажиллагч байгууллагатай хүүхэд хамгааллын стандартыг хэрхэн мөрдөн ажиллах талаар түншлэлийн гэрээнд тусган хамтран ажиллана. Энэхүү стандарт мөрдөгдөөгүй алдаа, зөрчил гарсан тохиолдолд тухайн байгууллагатай хийсэн гэрээ цуцлахад хүрнэ

Эрсдэлийн Менежмент

Хөтөлбөрийн эрсдэлийн менежментийн үнэлгээг төсөл боловсруулалтын үе шатанд болон төсөл хэрэгжиж эхлэх үед хийж эрсдэлээс хамгаалах зөвлөмжүүдийг цаг тухай бүрт гарган эрсдэлээс хамгаалагдаж байдаг. Мөн хөтөлбөрийн үе шат бүрт Sight For All-н удирдах зөвлөлийн гишүүд эрсдэлийн үнэлгээнд хяналт тавьж ажилладаг.

Хүүхдийн Зураг Авах

Sight For All-н төлөөлөгчид гэрэл зураг авахдаа хувь хүний нэр төрийг хүндэтгэх, зурганд орсон хүмүүсийн эрх, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангахын ач холбогдлыг мэддэг байх ёстой. Зураг нь тухайн орчин, бодит байдлыг үнэн зөв дүрсэлсэн байх ёстой бөгөөд хувь хүн, орчин, байршил эсвэл нөхцөл байдлыг буруугаар илэрхийлэхгүй байх ёстой. Зураг бүрийг нь Sight For All-н төв оффисоос баталсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурж мэдээллийн хэрэгсэлээр хэвлэн нийтлэхийг зөвшөөрснийг баталгаажуулсан байна..

Мэдээлэх

Хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх бүх асуудлууд, аливаа сэрдлэг эсвэл мэдэгдэл мөн энэхүү хөтөлбөр эсвэл Sight For All-н Ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдлуудыг нэн даруй мэдэгдэх ёстой. Sight For All нь бүх мэдээлсэн асуудалд нухацтай хандаж, нэн даруй арга хэмжээ авдаг. Хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөгийн талаарх асуудлууд эсвэл мэдэгдлийг шалгахдаа Sight For All нь нууцлалыг хангаж, шударга ёсны зарчмуудыг баримтлах болно.

Хүүхдийн хүчирхийлэл, мөлжлөгийн сэжигтэй эсвэл бодит үйлдлийг хэн ч мэдээлэх боломжтой. Sight For All-н хүүхэд хамгааллын бодлого эсвэл эмзэг бүлгийн хүмүүстэй харьцах ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа үйлдлийг мэдээлэх ёстой. Хүүхдийн садар самуун эсвэл хүүхдийн мөлжлөгтэй холбоотой материалыг үзсэн, эзэмшсэн сэрдлэг эсвэл нотолгоог, мөн хүүхдийн зургийг зохисгүй авсан үйлдэл, Sight For All-н үйл ажиллагаанд оролцсоны үр дүнд хүүхдэд учирсан эрсдэл, хохирлыг мөн мэдээлэх ёстой.

Мэдээллийг 24 цагийн дотор хүлээн авна.

Хэрэв миний харсан зүйл хүүхдийн мөлжлөг, хүчирхийлэл гэдэгт итгэлгүй байвал яах вэ?

Хүүхдийн мөлжлөг, хүчирхийлэл гэж юу болох эсвэл бодлогыг дагаж мөрдөхгүй байх талаар нэмэлт мэдээлэл болон нууц зөвлөгөө авахыг хүсвэл хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтан эсвэл Sight For All-н суурин төлөөлөгчийн мэргэжилтэнтэй холбогдоно уу.

Хэрхэн мэдээлэх вэ?

Та дараах цахим хаяганд хандан мэдээлэл өгнө үү : <https://sightforall.org/complaints/>

Доорхи Sight For All-ийн суурин төлөөлөгчдөд хандана уу

Sight For All-н Гүйцэтгэх Захирал – jhatswell@sightforall.org

Монгол/Шри-Ланка/Мьянмарын суурин төлөөлөгч – myanmarcountryofficer@sightforall.org

Камбожын суурин төлөөлөгч – cambodiacountryofficer@sightforall.org

Шри-Ланкын суурин төлөөлөгч – srilankacountryofficer@sightforall.org